



СМДӨАЭАХХГазар

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272287

[И-мэйл](#)

Аудитын менежер:

Т.Майцэцэг

Утас: 70273465

СТАудитын багийн: Шинжээч

Ц.Хишигжаргал

Утас: 70273204

И-мэйл: khj_616@yahoo.com

ТӨАГ-ын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-9
• Гол шийдлүүд	9
• Залруулаагүй алдаа	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	10
• Аудитын санал дүгнэлт	10

СМДӨАЭАХХГ-ын 2013 оны Санхүүгийн тайланд

ААГазар аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид СМДӨАЭАХХГ-ын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. СМДӨАЭАХХГ-ын төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд СМДӨАЭАХХГ-ын тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

Байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайланд аудит хийлээ.

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөөгүй, орлогод бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, үндсэн үйл ажиллагааны орлогыг дансанд зөв бүртгэн тусгах шаардлагатай байна.
- Кассаар дамжуулан бэлэн мөнгөөр иргэдээс худалдан авсан бараа материалын үнээс суутгаж аваагүй татвар 5413.0 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлэх төлбөрийн акт бичив.
- Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5-д заасны дагуу ажилчдад олгосон тэтгэмж болох 7243.5 мянган төгрөгийг нийгмийн халамжийн зардалд урьдчилан төсөвлөж суулгаагүй байна.
- Дээд шатны байгууллага болох ШШГЕГазар нь хэт өндөр үнэтэй бараа материалыг үнэ төлбөргүй гэж шилжүүлж байгаа нь тухайн байгууллагуудын бараа материалын зардал өсөхөд шууд нөлөөлж байна.

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн нийт зөрчлийн хэмжээгээр агуулгаараа урьдчилан тогтоосон материаллагын түвшингээс их байгаа учир **хязгаарлалттай санал дүгнэлт** гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан.

- Ерөнхий Аудитор 2014.02.15-ний өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан бодогч Ж.Бат-Эрдэнэ болон бидэнтэй хамтран ажилласан ажилтнуудад гүнээ талархаж байна.

Аймгийн Аудитын газар

2014.02.11

Танилцуулга

1. Бид СМДӨАЭАХХГ-ын 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. СМДӨАЭАХХГ-ын даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд ШШАлба нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

2. Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

1. Аймгийн Аудитын Газар нь 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалтын үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

2. Дараах 8-н түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд СМДӨАЭАХХГ-ын удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Орлого, санхүүжилтийн талаар

- Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого, урсгал санхүүжилт 723352.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 2600.0 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 16269.9 мянган төгрөг, ялтаны нэрийн дансны орлого 3740.3 мянган төгрөг, НДХэлтэсээс 131.1 мянган төгрөг нийт 746093.5 мянган төгрөгийн эх үүсвэртэйгээр ажилласан байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 745962.4 мянган төгрөг НДХээс авсан 131.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- ШШГЕГазраас СМДӨАЭАХХГазрын 2013 оны урсгал зардлын төсвийг 735517.5 мянган төгрөгөөр төсвөөс санхүүжих, 2000.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр нийт 737517.5 мянган төгрөгөөр баталж сар бүрийн төсвийн хуваарийг гаргасан байна. Тайлант оны гүйцэтгэлээр 746093.5 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 8578.0 мянган төгрөгөөр илүү санхүүжсэн байна.
- Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөөгүй, орлогод бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, үндсэн үйл ажиллагааны орлогыг дансанд зөв бүртгэн тусгах шаардлагатай байна.

2. Мөнгөн хөрөнгө

- Төрийн сан дахь харилцах дансаар болон байгууллагын мөнгөн кассаар нийт 746093.5 мянган төгрөгийн санхүүжилт, болон бусад орлогыг төвлөрүүлж үйл ажиллагааны холбогдох зардал, ялтны ажлын хөлс зэрэгт нийт 737978.5 мянган төгрөгийг зарцуулан 8115.0 мянган төгрөг үлдсэнээс 7804.5 мянган төгрөгийг дээд газарт татан төвлөрүүлж ялтны нэрийн данс буюу дотоод

тооцооны үлдэгдэл 310.5 мянган төгрөг нь харилцах дансанд 200.0 мянган төгрөг, кассд 110.5 мянган төгрөг үлдсэн гэж тайлагнасан байна.

- Харилцах дансны гүйлгээг шалгахад Монтех трэйд ХХК-ны дансанд 17 удаагийн шилжүүлгээр 77985.0 мянган төгрөг, ШТН нэгдлийн дансанд 5удаагийн шилжүүлгээр 43486.9 мянган төгрөг, байгууллага өөрийн чекээр болон бусад орлогын мөнгө 12205.8 мянган төгрөг нийт 133677.7 мянган төгрөгийг бэлнээр авч зарцуулсан байна. Мөн ШШГЕГ-ын дансанд бэлнээр 23650.4 мянган төгрөгийг хүнсний материалын үнэ гэж тушаасан, бусад харилцагч байгууллагуудтай өндөр дүнтэй гүйлгээ бэлнээр гүйцэтгэдэг зөрчил байна. Энэ нь Төсөвт байгууллагад мөрдөгдөх Сангийн сайдын 2012 оны 12-р сарын 21 ны өдрийн 276 тоот тушаалыг ноцтой зөрчсөн байхад шууд удирдах дээд байгууллага ШШГЕГазар нь хяналт тавьж ажиллаагүй улмаар өөрөө энэ тушаалыг зөрчсөн байна.
- Кассаар дамжуулан бэлэн мөнгөөр иргэдээс худалдан авсан бараа материалын үнээс суутгаж аваагүй татвар 5413.0 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлэх төлбөрийн акт бичив.

3. Цалингийн талаар

- Цалингийн программаас Excel файлаар хөрвүүлэн 1-12 сарын цалингийн цэсийг нэгтгэн шалгахад нийт 337232.5 мянган төгрөгийг олгохоор тооцсон байхад харилцахын гүйлгээгээр ажилчдын цалингийн картанд 347690.5 мянган төгрөг шилжсэн ба 10458.0 мянган төгрөгийн зөрүүтэй. Энэ нь ажилчдад олгосон шагнал, тэтгэмж, листны мөнгө зэргийг тусд нь бодож олгосон байдлаас шалтгаалсан байна.
- Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5-д заасны дагуу ажилчдад олгосон тэтгэмж болох 7243.5 мянган төгрөгийг нийгмийн халамжийн зардалд урьдчилан төсөвлөж суулгаагүй байна.
- Цалинг PAYROLL программ ашиглан сарын сүүлд бодож олгохдоо суутгалын зөрүү гарсан дүнг авлагын дансанд тусгадагүй байна. Тайлант онд нийт 2295.6 мянган төгрөгийн авлагыг суутгаж барагдуулсан ба ажилчдад урьдчилгаа цалинг олгохдоо өндөр дүнгээр олгодгоос сарын сүүлд суутгагдахгүй үлдэж авлага үүсгэж байна. Цалингийн татварын тооцоог 68.4 мянган төгрөгийн авлагатай байна. Энэхүү өглөг нь 2013 оны эхний үлдэгдэл бөгөөд тайлан тэнцэлд тусгагдаагүй байна.
- НДШ-д даатгуулагчаас цэргийн албан хаагчид ба энгийн албан хаагчид гэсэн ялгавартай суутгагддаг ба ажил олгоч нь 11-н хувиар тооцож шимтгэл төлдөг байна тайлант онд цалингаас 43192.8 мянган төгрөгийг тооцоолон шилжүүлсэн ба НДХэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. НДХ-н тодорхойлсоноор тус байгууллага нь 49.7 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна.
- Цалингийн карт хөтөлсөн байдлыг шалгахад хүн тус бүрт карт хөтөлдөггүй, цалингийн цэсэнд гарын үсэг зуруулдаггүй байна. Нийт орон тоо 47, дарга 1, гүйцэтгэх ажилтан 9 хүний бүрэлдэхүүн ажилласан байна. 2012 оны Засгийн газрын 78-р тогтоолын дагуу албан хаагчдын цалингийн шатлал, сүлжээний дагуу цалинг зөв тогтоосон байна.

- Дээрх цалингийн татварын авлага 68.4 мянган төгрөг, мөн НДХ-ээс авах 49.7 мянган төгрөг нийт 118.1 мянган төгрөгийг байгууллагын дарга нягтлан бодогч нараар хувь тэнцүүлэн төлүүлэхээр төлбөрийн акт бичив.

4. Бараа үйлчилгээний зардал

- Бараа үйлчилгээний зардал нь батлагдсан төлөвлөгөөгөөр 303713.5 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 304460.8 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 747.3 мянган төгрөг хэтэрсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Бараа, үйлчилгээний зардал нь 305045.8 мянган төгрөгөөр тусгагдсан ба үүнд төвлөрүүлэх шилжүүлэг 7804.5 мянган төгрөгийг зардлын дүнд оруулж тусгасан байна. Бараа үйлчилгээний нийт зардал нь бага дүнгээр хэтэрсэн мэт харагдаж байгаа боловч зардал хооронд буюу тогтмол зардлаас 13310.2 мянган төгрөг, хоолны зардлаас 5406.4 мянган төгрөг нийт 18716.6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна. Мөн эмийн зардалд 14679.1 мянган төгрөг, урсгал засварын зардалд 8593.0 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.
- Гэрэл цахилгааны зардлаас 5966.0 мянган төгрөг, түлш халаалтын зардлаас 7344.2 мянган төгрөг хэмнэсэн боловч нийт 13310.2 мянган төгрөгийн зардлуудыг гүйлгэн зарцуулсан байна.
- Тээвэр шатахууны зардалд 15000.0 мянган төгрөг батлагдаж 15180.2 мянган төгрөг зарцуулсан ба 180.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан гэж тайлагнасан боловч харилцах данснаас 15398.2 мянган төгрөг, кассаас бэлнээр 872.5 мянган төгрөг нийт 16270.7 мянган төгрөг зарцуулсанаас 1270.7 мянган төгрөгийн бодит хэтрэлт гарсан байна.
- Урсгал засварын зардалд 2200.0 мянган төгрөг батлагдсан боловч 10793.0 мянган төгрөг зарцуулж 8593.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Сэлбэг хэрэгсэлийн зардалд 4530.7 мянган төгрөг зарцуулсан ба үүнд өндөр үнэтэй сэлбэг хэрэгсэл засвар үйлчилгээ хийлгээд уг хөрөнгийг/автомашиныг/ капиталжуулж данс бүртгэлд тусгаагүй, автомашинд засвар үйлчилгээ сэлбэг хэрэгсэл авч тавих талаар техникийн комиссын тогтоосон акт байхгүй, буруутай этгээдийг тогтоож хариуцлага тооцдоггүй байна. Барилгын засварт 5608.1 мянган төгрөгийн материал зарцуулсан ба урсгал засвар хийх тухай гэмтлийн акт тогтоож шаардагдах материалыг тооцож төсөвлөөгүй байна. Мөн барилгын засварын материалын дүнд 140.0 мянган төгрөгийн үнэтэй насос /тоног төхөөрмж/-ыг зардал болгож данснаас хассан байна. Иймд холбогдох этгээд болон материалын няраваар төлүүлэх төлбөрийн акт бичив.
- Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын журнал, ТС-гийн хуулга, ЕД, ЕЖ, өглөг авлагын дэлгэрэнгүй журнал, АШБаримтыг ашиглан шалгав. Санхүүгийн тайлангаар бараа үйлчилгээний урсгал зардал нийт дүнгээрээ хэтрэлттэй, зардлын хооронд гүйлгэн зарцуулсан байна.

5. Үндсэн хөрөнгө

- Санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн эхний үлдэгдэл 779033.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 796089.1 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн үлдэгдэлтэй тулгахад тохирч байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр тоног төхөөрмж 8047.9 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө

- 4300.0 мянган төгрөгөөр нийт 12347.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна. Мөн 4708.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр шилжин ирж нийт 17056.7 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн дүн нэмэгдсэн ба атклаж хасагдсан үндсэн хөрөнгө байхгүй байна. Дээрх хөрөнгүүдийг бэлтгэхдээ ТӨХороо болон ШШГЕГазраас зөвшөөрөл аваагүй байна. Хөрөнгийн үлдэгдлийг жилийн эцсэст тооллого хийсэн бүртгэлтэй тулган шалгахад тооллогын бүртгэл болон тооцоо бодсон тухай комисс гарын үсэг зурж албажуулсан байна. Тус байгууллага нь жилийн эцсийн тооллогыг байгууллагын даргын 2013 оны 12 сарын 20-ны өдрийн А/30 тоот тушаалаар тооллогын комиссыг томилж үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн байна.
- ТӨХороо болон ШШГЕГазрын зөвшөөрөлгүйгээр төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө худалдан авч бэлтгэсэн байна.

6. Бараа материал

- Санхүүгийн байдлын тайлангаарх бараа материалын эхний болон эцсийн үлдэгдэлийн дүнг, Бараа материалын тодруулгын тайлангийн дүнтэй тулгахад тус бүр тохирч байна. Бараа материалын тодруулгын тайлангийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн орлогын дүн 225674.9 мянган төгрөг байна.
- Түлш халаалтын зардлыг бараа материалын тайлангаас түүвэрлэн үзэхэд тус байгууллага нь тайлант онд нийт 1580.2 тонн нүүрс буюу 44987.3 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Эндээс тооцож үзвэл тухайн байгууллагад ашиглагдаж байгаа уурын зуухнуудын норматив нь бүрэн хүчин чадлаар буюу оргил ачаалалтай үедээ хоногт 5.2 тонн, сард 161.2 тонн, галлагааны хугацаатай 8 сард 1289.6 тонн нүүрс зарцуулахаар байхад 1580.2 тонн нүүрс зарцуулж 290.6 тонн нүүрс илүү зарцуулсан байна. Иймд нормативаас илүү зарцуулсан нүүрсний үнэ болох 290.6×20.0 мянган төгрөг = 5812.0 мянган төгрөгийг тухайн байгууллагаар төлүүлэх акт бичив.
- Тус байгууллага нь шатахууны зардалд 16270.7 мянган төгрөг зарцуулсан ба гүйцэтгэсэн ажлыг шалгахад батлагдсан маршрут байхгүй, замын хуудас бичиж шатахуун зарцуулалтанд хяналт тавидаггүй, жолоочийн тооцоог боддоггүй, ажил гүйцэтгэсэн тухай хянаж баталгаажуулсан анхан шатны баримтууд байхгүй байна. Хэнтий аймагт аялалаар явахдаа төсвийн хөрөнгөөр авсан шатахууны үнэ 713.5 мянган төгрөг, тэмцээнд явахдаа зарцуулсан 308.6 мянган төгрөг, сонгуулийн ажилд зарцуулсан 164.0 мянган төгрөгийг шийдвэр гаргасан албан тушаалтнаар, нийт 1186.1 төгрөгийн шатахууныг төлүүлэх төлбөрийн акт бичив.
- Эм тарианы зардалд 85000.0 сая төгрөг төсвөлсөнөөс 99679.1 мянган төгрөг зарцуулж 14679.1 мянган төгрөгөөр төсвийг хэтрүүлсэн байна. Бараа материалын данс дахь эмийн эцсийн үлдэгдэл 10231.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба 2014 эхэнд 14507.4 мянган төгрөгийн буюу 2 сар хэрэглэх нөөцтэй байна. Мөн давхардсан тоогоор 112 нэр төрлийн 6524.2 мянган төгрөгийн эм нь худалдаж авсанаас хойш нэгч ширхэгийг зарлагадаагүй буюу зайлшгүй шаардлагатай биш эм тариаг их хэмжээгээр нөөцөлсөн байна. Нэр төрлөөр авч үзвэл 3481/фл/ ширхэг буюу 2870.9 мянган төгрөгийн хлораминыг бүтэн жилийн хэрэгцээгээр нөөцөлсөн ба тухайн байгууллагад нэг бүр нь 560 төгрөгийн үнэтэй 2040 фл байхад ШШГЕГазраас нэг бүрийг нь 1200 төгрөгөөр 1440 фл-ыг

ирүүлсэн байна. Мөн эм боох материалын дансанд 700.0 мянган төгрөгийн кварцын гэрлийг буруу ангилан бүртгэсэн зэрэг зөрчлүүд байна.

- Дээд шатны байгууллага болох ШШГЕГазар нь хэт өндөр үнэтэй бараа материалыг үнэ төлбөргүй гэж шилжүүлж байгаа нь тухайн байгууллагуудын бараа материалын зардал өсөхөд шууд нөлөөлж байна.
- Хүнс материалын зардалд 104733.5 мянган төгрөг төсөвлөсөн ба мөнгөн гүйлгээний тайлангаар 99327.1 мянган төгрөг зарцуулсан гэж тайлагнасан байна. Хүнсний материалын дансанд 77461.0 мянган төгрөгийн бараа материал төсвийн хөрөнгөөр худалдан авсан гэж тайлагнасан ба 21866.0 мянган төгрөгийн хүнсний материалыг шууд зардал болгосон гэж харагдаж байна.
- Төрийн алба болон гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй холбогдолгүй /нам, олон нийтийн байгууллагын/ сонин хэвлэлийг олноор захиалж 286.6 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан байна. Бараа материалыг дансанд тусгахдаа зөв ангилан бүртгээгүй, хуулийн хугацаанд тооллого хийж, тооцоо бодсон гэх боловч үр дүн муутай болсон байна. Төрийн алба болон гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй холбогдолгүй сонин хэвлэлийн үнэ болох 286.6 мянган төгрөгийг байгууллагын удирдлагуудаар төлүүлэх төлбөрийн акт бичив.
- Бараа материалын тооллого, тооцоо бодолт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зохих журмын дагуу хийддэггүй, бараа материалын шаардах хуудсыг бүрэн бөглөдөггүй, бараа материал орлого авсан дүнгээр нь нэг дор зарлага бичиж гаргаж байна.
- Складаас гарч байгаа бүх төрлийн бараа материалыг шаардах хуудсаар олгодог боловч дугаарлагдаагүй, зөвшөөрсөн, хүлээлгэн өгсөн болон авсан хүний гарын үсэг бүрэн зурагдаагүй, зарлагын баримтанд хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан хүний гарын үсэг огт зурагдаагүй падааныг нэг дор бөөн бичиж баримтанд хавсрагадаг байна.

7. Авлага, өглөгийн талаар

- СМДӨАЭАХХГазар нь 2013 оны эхэнд авлага өглөгийн тооцоогүй гэж тайланд тусгасан байна. Авлага, өглөгийг журналаас тулган үзэхэд байгууллага хувь хүмүүстэй 244747.8 мянган төгрөгийн авлага үүсгэж 244090.7 мянган төгрөгийг барагдуулсан ба 657.0 мянган төгрөгийн авлагатай байна. Мөн тайлант онд цалин, НДШ, ХАОАТатаврт нийт 487298.7 мянган төгрөгийн өглөг тооцоолж барагдуулсан байна.
- Дээрх авлага, өглөгийг нэг бүрчлэн авч үзэхэд Татварын хэлтэсээс 68.4 мянган төгрөгийн авлагатай байсныг 2013 оны эхэнд дансанд тусгаагүй, оны эцэст НДХэлтэстэй тооцоогүй гэж тайлагнасан боловч 49.7 мянган төгрөгийн илүү төлөлт буюу авлагатай байна. Мөн Тэспетролиум ХХК-аас шатахууны үнэ 588.6 мянган төгрөгийн авлагатай байна. Харилцагч байгууллага болон хувь хүмүүстэй хийсэн ажил гүйлгээг тооцоо нийлсэн актаар тухай бүр баталгаажуулаагүй байна.
- Иймд урьд оны авлага 68.4 мянган төгрөг, данс бүртгэлд тусгаагүй авлага 49.7 мянган төгрөг нийт 118.1 мянган төгрөгийг байгууллагын дарга нягтлан бодогч нараар хувь тэнцүүлэн төлөөлэхээр төлбөрийн акт бичив. Мөн урьдчилан төлсөн шатахууны мөнгө 588.6 мянган төгрөгийг 2014 оны төсвөөс хасаж, аймгийн төсөвт оруулах акт бичив.

8. Дотоод хяналт шалгалт

- МУ-ын ЗГазрын 2011.11.09-ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” -ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэж заасны дагуу дотоод хяналтын алба томилож ажиллаагүй байна.
- ШШЕГазрын даргын 2013 оны 6-р сарын 19-ны өдрийн б/826 тоот тушаалаар тус албаны хэмжээнд “дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал, хяналт шинжилгээ, үнэлгээ”-г хариуцсан ажилтанаар дэд дарга, дэд хурандаа Б.Энхтайваныг томилон ажилуулсан байна. Дотоод хяналтын ажилтан нь төлөвлөгөөний дагуу сар улирал бүр хяналт хийсэн тухай товч илтгэх хуудаснаас өөр дэлгэрэнгүй тайлан болон баталгаажуулсан баримтууд байхгүй байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудитын явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ✓ Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг зөв тайлагнаж байх
- ✓ Төсвийн төлөвлөлтийг бодитой хийж зардал хооронд нь гүйлгэн зарцуулахгүй байх
- ✓ Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөх

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Эдгээр залруулагдаагүй алдаанууд байгууллагын удирдлагын анхаарлын төвд хүргэгдэх болно. Залруулагдсан алдаа байхгүй болно

Тайлбар мэдүүлгийн захидал

7. Аудитын үйл явцад аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх зөвлөмжийн биелэлт

Өмнөх жилүүдэд тухайн байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийгдэж байгаагүй ба ШШГЕГазрын дотоод аудит нь байгууллагуудад түүвэрлэн шалгалт хийсэн байна.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн аудитын газраас тус тайланд мөнгөн хөрөнгө, бараа материалын зардлын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар.